

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА ЛУВСАНСАМДАНГИЙН ОЧГЭРЭЛИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл тийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)						
			1	2	3	4	5				
<b>1. Аюулгүй байдлын чиглэлээр</b>											
1	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцон эрсдэлийг бууруулах талаар авсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох зорилго бүхий санал асуултыг нийт 19 газар, хороодын 1069 төрийн төрийн албан хаагчдаас авч нэгтгэсэн. Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох судалгааг эрсдэл тооцох аргачлалын дагуу хэрэгжүүлж, 67%-ийн үнэлгээгээр үнэлэгдсэн.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох гаалийн байгууллагын эрсдэлийг бууруулах талаар эрсдэлийн удирдлагын олон улсын аргачлал (WCO Risk Management Compendium, ISO 31000) болон холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, сахилгын зөрчил, гомдол мэдээллийг дүгнэх албан хаагчдын хандлага, ажиллах нөхцөл, сэтгэл ханамжийг тодорхойлох, байгууллагын манлайлал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд судалгаа дүн шинжилгээ хийж үр дүнд тулгуурласан чиглэл зөвлөлмжийг ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтэс, харьяа гаалийн газар газар хороодод ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж ажиллаа. Үүнд: 1.1.Хууль тогтоомжийн эрсдэлийн судалгаа: Google Form ашиглан 9 асуулгатай судалгаа явуулж, 510 албан хаагч оролцсон. Тус судалгаанаас хууль тогтоомжийн мэдээллийг цаг хугацаанд нь авах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагч наарт сургалт зохион байгуулах, хууль тогтоомжид гарч буй эрсдэлийг багасгахад анхаарч ажиллах талаар дүгнэлт гарсан.	/Холбогдох судалгаа болон чиглэл хүргүүлсэн албан тоотыг хавсаргав/	1.Гаалийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, гаалийн байгууллагын эрсдэлийг бууруулах талаар эрсдэлийн удирдлагын олон улсын аргачлал (WCO Risk Management Compendium, ISO 31000) болон холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, сахилгын зөрчил, гомдол мэдээллийг дүгнэх албан хаагчдын хандлага, ажиллах нөхцөл, сэтгэл ханамжийг тодорхойлох, байгууллагын манлайлал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд судалгаа дүн шинжилгээ хийж үр дүнд тулгуурласан чиглэл зөвлөлмжийг ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтэс, харьяа гаалийн газар газар хороодод ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж ажиллаа. Үүнд: 1.1.Хууль тогтоомжийн эрсдэлийн судалгаа: Google Form ашиглан 9 асуулгатай судалгаа явуулж, 510 албан хаагч оролцсон. Тус судалгаанаас хууль тогтоомжийн мэдээллийг цаг хугацаанд нь авах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагч наарт сургалт зохион байгуулах, хууль тогтоомжид гарч буй эрсдэлийг багасгахад анхаарч ажиллах талаар дүгнэлт гарсан.	Судалгаагаар гарсан үр дүнг хууль тогтоомжийн хэрэгжилт хангальтгүй буюу эрсдэлтэй холбогдох ЧХОУНБГТ, СэГГ, ДоГГ, УХШИГГ, ГсГГ, Улс Шивээхүрэн ГГ, Баян-Өлгий ГГ, Ховд ГГ, Бичигт ГГ, СшГГ Ханги дахь	01-01 06-05	100 хувь		

			<p>гаалийн газар, Говь Алтай, Завхан, Хөвсгөл дэх гаалийн хороонд хүргүүлсэн.</p> <p>Судалгааны дүнд илэрсэн гол асуудлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>*Хууль тогтоомжийн мэдээллийг цаг хугацаанд нь авах</li> <li>*Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>*Албан хаагч нарт сургалт зохион байгуулах</li> <li>*Хууль тогтоомжид гарч буй эрсдэлийг багасгахад анхаарч ажиллах</li> </ul> <p><b>1.2. Хүний нөөцийн эрсдэлийн судалгаа:</b> Google Form ашиглан 12 асуулгатай судалгаанд 468 албан хаагч оролцсон. Судалгааны тайланг ГЕГ-ын дарга болон Захиргааны удирдлагын газарт болон Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн. Гол эрсдэлтэй асуудлууд :</p> <ul style="list-style-type: none"> <li>*Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, орон тоог нөхөх</li> <li>*Сэлгэн ажиллуулах журмыг ил тод, шударга болгох</li> <li>*Ажиллах, амьдрах нехцэлийг сайжруулах</li> <li>*Удирдлагын манлайлал, мэргэшлийг нэмэгдүүлэх</li> <li>*Шударга, ил тод байдал хангах</li> <li>*Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх</li> <li>*Хууль дүрэм, мэдээллийг түргэн шуурхай хүргэх</li> <li>*Хууль эрх зүйн зохицуулалт шинэчлэх, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх</li> <li>*Тусгай албадын эрх зүйн тэгш байдал хангах</li> </ul>	
2	Аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>- Мэдээллийн болон программ хангамж, дотоод сүлжээний аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж,</p> <p>Tус хэлтсийн чиг үүргийн хүрээнд мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих ажил арга хэмжээ тусгагдсан дагуу дараах ажил арга хэмжээг авч ажиллаа.</p>	01-01 06-05

		<p>Төлөвлөх ажлын хэмжигдэхүйц тоон болон чанарын үзүүлэлтийг тусгасан суурь үзүүлэлт, байгууллагын эрсдлийн түвшин - 33%</p>	<p>Хэрэгжилтийг хангуулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилга байгууламж, хөдөлмөрийн болон албаны нууцтай холбоотой бүх төрлийн мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.</li> <li>- Байгууллагын албан хаагчдын аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.</li> </ul>	<p>1. Мэдээллийн аюулгүй байдлын холбогдох 7 хууль, тогтоомж, 6 дүрэм журам, 7 стандартыг бүрэн эхээр нь авч сан бүрдүүлэн гаалийн газар, хороодод гарын авлага болох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нэг сангаас мэдээллийг олж мэдэх, хэрэгжүүлэх нехцлийг бүрдүүлэх зорилгоор хүргүүлэн СЕРР системд байршуулсан. Үүнд: Кибер аюулгүй байдал, Цахим гарын үсэг, Хүний хувийн мэдээлэл хамгаалах, Төрийн болон албаны нууц, Байгууллагын нууц, Төрийн мэдээлэл солилцоо, болон нээлттэй өгөгдлийн хууль, журмын мэдээлэл.</p> <p>Стандартууд: MNS ISO/IEC 27001:2023, 27002:2006, 27003:2021, 27006:2014, 27007:2024, 27035:2012, MNS 5969:2009.</p> <p>2. 2025.06.03-ны өдрийн 01-5/2364 дугаар албан тоотоор харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдад 7 агуулгаар 19 төрлийн мэдээллийн аюулгүй байдалд анхаарч ажиллах чиглэлийг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• ISO/IEC 27001 стандартын дагуух сургалтанд хамрагдсан.</li> <li>• ХАБЭ сургалтанд албан ГУАБ-ыг хамруулсан. Цаашид гаалийн газар хороодын хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэгдсэн тогтолцоонд оруулах ажил төлөвлөж байна.</li> <li>• Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тус хэлтсийн 2 албан хаагч хамрагдаж мэргэшсэн эрх авсан.</li> </ul> <p>2. Албан хаагчдын хөдөлгөөний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Албан хаагчдад хөдөө орон нутагт зорчих үед замын хөдөлгөөнд зөв, соёлтой оролцох тухай болон бүх нийтийн амралт, баяр ёслолын үед болон ээлжийн амралтын үед зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслээр зорчих, хувийн унаагаар бол ирсэн очисон үйлдлийг нэгжийн удирдлагадаа мэдэгдэж байх зэрэг санамж зөвлөмжийг тогтмол хүргүүлж байна.</li> </ul>	100 хувь
--	--	---	--	---	-------------

<b>2. Дотоод хяналтын чиглэлээр</b>						

3	Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн хяналт, шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ГЕГ-ын ЗБББНДБ, харьяа гаалийн газар, хороодын гэмт хэрэг зөрчилд холбогдсон, сахилга ёс зүйн зөрчил гаргасан	Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл шалгагдаж шийдвэрлэгдсэн байна. Хэрэгжилтэд хяналт тавьсан байна.	<p>1. Тайлант хугацаанд Сахилгын хорооны хуралдааныг 2 удаа зохион байгуулсан. ДХАБХ-т ирүүлсэн 26 удаагийн гомдол мэдээлэлд холбогдуулан 36 албан хаагчдад албаны дотоод шалгарт явуулж, холбогдох зөрчлийн танилцуулгыг бэлтгэн холбогдох ЭБАТ-д танилцуулсан. Үүнээс сахилга, ёс зүйн зөрчилд холбогдсон 11 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж ажилласан.</p> <p>2. Сахилгын хорооны бүрэлдэхүүнийг Сангийн сайдын сайдын баталсан чиг үүргийн хүрээнд шинэчлэн батлах тухай ГЕГ-ын даргын 2025 оны А/241 тушаалаар Сахилгын хорооны хурлыг зохион байгуулах ажлыг тус хэлтсийн ГУАБ –д хариуцулсан.</p>	01-01 06-05
---	--	-------------------------	---	---	--	----------------

			нийт 38 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан бол үүнээс 18 албан хаагчийн үйлдлийг ГЕГ-ын сахилгын хороогоор хэлэлцүүлэн хариуцлага тооцсон.		<p>3. 2024-2025 онд Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчидтай холбоотой иргэд/мөн тус газрын албан хаагчаас/-ээс гомдол мэдээлэл ихээр ирүүлж байгаатай холбогдуулан албаны шалгалтын санал, дүгнэлтийн хүрээнд тус газарт ажил сайжруулах чиглэл хүргүүлсэн.</p> <p>4. 2024 эхний хагас жилийн байдалтай харьцуулан үзвэл:</p> <table> <thead> <tr> <th>Төрөл</th><th>2024</th><th>2025</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Гомдол, мэдээлэл</td><td>32</td><td>25</td></tr> <tr> <td>Шалгагдсан албан хаагч</td><td>85</td><td>36</td></tr> <tr> <td>Сахилгын хороонд шилжүүлсэн</td><td>25</td><td>16</td></tr> <tr> <td>Сахилгын шийтгэл ногдуулсан</td><td>9</td><td>13</td></tr> </tbody> </table> <p>Дээрх байдлаас дүгнэхэд ирүүлсэн гомдол, мэдээлэлд холбогдуулан шалгагдсан албан хаагчдын тоо, ГЕГ-ын сахилгын хорооны хуралдаанаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн албан хаагчдын too буурсан байдал харагдаж байх боловч энэ үзүүлэлтийг 2024 оны эхний хагас жилийн тоотой харьцуулахад сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагчийн too ёссэн.</p> <p>5. 2023-2025 оны эхний 2 улиралын байдлаар сахилгын арга хэмжээ авагдсан албан хаагчдын үйлдэл, зөрчлийн төрөл, байршил, хүйсийн байдлаар дүн шинжилгээ хийж дотоод сүлжээнд байршуулсан.</p> <p>6. Мөн сахилгын хорооны хурлаар орсон албан хаагчдын үйлдэл, ногдуулсан хариуцлагын мэдээллийг дотоод сүлжээний мэдээ мэдээллийн хэсэгт байршуулж албан хаагчдыг гэмт хэрэгс зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хийгдсэн.</p> <p>6. 2025 оны эхний хагас жилийн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй 2 албан хаагчийг Сахилгын хорооны шийдвэрээр Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар шилжүүлсэн.</p>	Төрөл	2024	2025	Гомдол, мэдээлэл	32	25	Шалгагдсан албан хаагч	85	36	Сахилгын хороонд шилжүүлсэн	25	16	Сахилгын шийтгэл ногдуулсан	9	13	
Төрөл	2024	2025																			
Гомдол, мэдээлэл	32	25																			
Шалгагдсан албан хаагч	85	36																			
Сахилгын хороонд шилжүүлсэн	25	16																			
Сахилгын шийтгэл ногдуулсан	9	13																			
4		-Гомдол мэдээллийн сан бүрдсэн.  -Сургалт, соён гэгээрүүлэх 3 ажил хийгдсэн	-Гаалийн байгууллагын хэмжээнд албан шалгалтыг гүйцэтгэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод шалгалтыг хяналт хэрэгжүүлнэ.	<p>1. Гаалийн ерөнхий газрын дотоод хяналт, аюулгүй байдлын нэгжид 2023-2025 оны эхний хагас жилийн хугацаанд ирүүлсэн гомдол мэдээллийн санг тогтмол баяжилт хийж 2025 оны эхний хагас жилийн байдлаар 108 гомдол мэдээллийг шалгасан сан үүсээд байна.</p> <p>Гомдол мэдээллийн судалгааны талаар:</p> <p>2023 онд гомдол мэдээлэл 58 байсан бол 2024 онд 72 болж 24%-иар ёссэн, 2025 оны эхний улиралд 26 бүртгэгдсэн нь жилийн түвшинд дунджаас ёссэн. Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл нийт гомдлын дийлэнх хувийг эзэлж байна. Үүнээс харвал 2024 онд 29</p>	01-01 06-05	100 хувь															

Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-Сахилга ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлаар 71 албан хаагчид шийтгэл ногдуулсан	-Шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцсон байна.	(40%), 2023 онд 24 (41%) байна. Гомдол мэдээлэл ирүүлсэн байдал нь ЗГ-ын "11-11" болон Гаалийн лавлах "1800-1281" сувгаар хандсан байна. ГЕГ-ын харьяа газар хороодоос ЭБАТ-аас ирүүлсэн зөрчлийн мэдээлэл нэмэгдсэн байна. Шалгалтад холбогдсон албан хаагчдын тоо: 2023 онд 172, 2024 онд 142, 2025 оны эхний улирлын байдлаар 38 байгаа нь 2025 оны 1-р улиралтай харьцуулахад өмнөх жилүүдтэй ойролцоо түвшинтэй байна. Сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагчид: •2023 онд 49 албан хаагчдад •2024 онд 72 албан хаагчдад •2025 онд 7 албан хаагчдад тохиолдол. Сахилгын шийтгэлийн төрөл, эзлэх хувиар харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ хийсэн.Үүнд: •2023 онд "Албан тушаалын цалинг 3 сар 20% бууруулах" (41%), "сануулах" (33%), "нээлттэй сануулах" (14%) зонхильтсон. •2024 онд "сануулах" (63%), "Албан тушаалын цалин 3 сар 20% бууруулах" (14%), "ГУБ-ын зэрэг дэв бууруулах" (7%) давамгайлсан. •2025 онд "Албан тушаалын цалинг бууруулах" (43%), "нээлттэй сануулах" (14%), "ГУБ-ын эрх хасах" (29%) хувийг эзэлж байна.Сахилгын шийтгэлийн төрөл нь "сануулах" арга хэмжээ дийлэнх хувийг эзэлж байна. Зөрчлийн үйлдлийн төрөл: 2023–2024 онд •"ёс зүйн зөрчил" (20%), •"албан тушаалын байдлаа урвуулан ашигласан" (20%), •"бусад сахилгын шийтгэл ( $\approx$ 30–38%) ногдуулсан байна. 2025 онд •"бусад сахилгын шийтгэл" (44%) нь өссөн, •"албан тушаалын байдлаа урвуулан ашигласан" (19%) болон "ажил тасалсан" (19%) байна. Нийт сахилгын зөрчлийн дийлэнх хувь нь "ажилдаа хайнга хандсан", "бусдад татвар төлөхөөс зайлсхийг боломж олгосон" зөрчлийн үйлдлүүд давтагдаж байна. Хүйс ба газар/хороогоорын ангилал: •2023–2024 онд эрэгтэй, эмэгтэй албан хаагчид ойролцоо ( $\approx$ 50:50). •2025 онд эрэгтэй 71%, эмэгтэй 29% эзэлж байна. ЗУГГ, УБГГ, ЧХОУНБГГ, ГЕГ-ын /ЗББДБ/ албан хаагчдын зөрчлийн тоо нэлээд өндөр үзүүлэлттэй.			

					<p>Сахилгын зөрчлийн талаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийтлэг байдлаар "Сануулах" арга хэмжээ их авагдсан байгаа нь зөрчилд хүлээлгэх хариуцлага сүл байна. Албан тушаалын ашиг сонирхлын зөрчил буурахгүй байна.</li> <li>• Давтагдсан зөрчлийн үйлдэл (ажилдаа хайнга хандсан, татвар төлөхөөс зайлхийх боломж олгосон, албан тушаалаа урвуулан ашигласан г.м) гарч буйг анхаарах шаардлагатай байгаа ГЕГ-ын ЗББНДГ-уудад вайбер группээр дамжуулан газрын удирдлагуудад хүргүүлсэн.</li> </ul> <p>Энэ төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх дараах 2 үндсэн чиглэлээр доривтой ажил зохион байгуулах уургийг хүргүүлсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Албан хаагчдын хариуцлагын нэмэгдүүлэх</li> <li>✓ Байгууллагын соёл, манлайллыг сайжруулах</li> </ul> <p>Тус хэлтэс 2025 оны эхний хагса жилийн байдлаар 26 гомдол мэдээлэл шалгаж шийдвэрлэсэн байна.</p> <p>Гомдол ирүүлсэн төрлөөр ангилвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын 1111 төвөөс ирүүлсэн – 2</li> <li>• Гаалийн лавлах 1800-1281 дугаарт ирүүлсэн 6</li> <li>• Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас дотоод зурсаасар ирүүлсэн – 5</li> <li>• Албан бичгээр хандаж гаргасан - 10</li> <li>• Бичгээр өргөдөл гомдол гаргасан – 3</li> </ul> <p>Үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зөрчлийн шалтгааныг судлах, урьдчилан сэргийлэх ажлыг нэмэгдүүлсэн.</li> <li>• Давтагдсан зөрчлүүдийн эсрэг хариуцлага чангатгасан.</li> <li>• "Сануулах" шийтгэл давамгай байгаа тул хариуцлагын түвшинг нэмэгдүүлсэн.</li> <li>• Албан тушаалын ашиг сонирхлын зөрчилд онцгой анхаарч урьдчилан сэргийлэх ажил, зөвлөмж хүргүүлсэн.</li> </ul>		
5	Гаалийн байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалт хийх, гарсан үр дүнгээр зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих,	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой нийт 72 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, хуулийн хүрээнд бүрэн	-Гаалийн байгууллагын хэмжээнд албан шалгалтыг гүйцэтгэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод шалгалтыг хяналт хэрэгжүүлнэ. -Шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлж,	2025 оны 06 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Улаанбаатар хот дахь гаалийн газарт Гаалийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг төлөвлөгөө, "Шударга байдлын үнэлгээ" төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, биелэлийг шалгахаар төлөвлөгөөт шалгалт хийсэн. Тус төлөвлөгөөт шалгалтаар Амгалан ложистик ГХБ болон Техник импорт, Туушин, АБТЕМА гаалийн	01-01 06-05	100 хувь

	Үр дүнг тооцсон байдал	шийдвэрлэсэн байна. 2.ГЕГ-ЫН ЗБББНДБ, харьяа гаалийн газар, хороодын гэмт хэрэг зөрчилд холбогдсон, сахилга ёс зүйн зөрчил гаргасан нийт 38 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан бол үүнээс 18 албан хаагчийн үйлдлийг ГЕГ-ЫН сахилгын хороогоор хэлэлцүүлэн хариуцлага тооцсон.	хэрэгжилтийг хангуулах үр тооцсон байна.	дүнг	<p>хяналтын бүсүүдэд ажиллаж тухайн хяналтын бүсэд ажиллагдын цаг ашиглалт, үйлчилгээний стандарт зэргийг шалгасан. Мөн ГХБ-ээр үйлчлүүлэгч нарт авлига, ашиг сонирхлын талаар мэдээлэл өгөх боломжийг хангаж гомдол мэдээллийг газар дээр нь авах, судалгаа гаалийн байгууллагын албан хаагчдын талаар судалгаа авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.</p> <p>- ДХАБХ-т 2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ГЕГ-ЫН гомдол мэдээлэл хүлээн авах тусгай дугаар 1800-1281, Засгийн газрын 11-11 төв, албан бичиг, дотоод зурvasaар нийт 26 гомдол мэдээлэл ирүүлснийг хүлээн авч 36 албан хаагчид албаны дотоод хяналт, шалгалт явуулсан. Үүнээс сахилга, ёс зүйн зөрчилд холбогдсон 11 албан хаагчийг Сахилгын хороогоор хэлэлцүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гомдол мэдээлэл – 26</li> <li>• Шалгагдсан албан хаагч – 36</li> <li>• Сахилгын хороонд шийлжүүлсэн – 16</li> <li>• Салхилгын хорооноос арга хэмжээ авсан -11</li> </ul> <p>-2023-2025 оны эхний улирлын байдлаар гаалийн байгууллага албан хаагчтай холбоотой иргэд, аж ахуйн нэгж болон харьяа гаалийн газар хороодын дарга нараас ирүүлсэн гомдол мэдээллийн санд судалгаа, дун шинжилгээ хийж, зөвлөмж, чиглэл хүргүүлжээ.</p> <p>-Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд албан хаагчдад сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр /ажлын байрны болон цахим, танхимины/ сургалтыг тасралтгүй зохион байгуулах, сургалтын чанарыг сайжруулах үүднээс "Сургалт + Сануулга + Шалгалт" гэсэн хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах ажлыг зохион байгуулах талаар тухай бүр зөвлөмж чиглэл бичгээр болон аман хэлбэрээр өгч байна.</p> <p>-Сахилгын болон ёс зүйн зөрчилд холбогдож арга хэмжээ авагдсан албан хаагчдын талаар "Ил тод, нээлттэй" мэдээлж гарсан зөрчлийг арилгах чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ авч ажиллахыг тухайн гаалийн газар хороонд чиглэл хүргүүлсэн..</p> <p>Зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байдал:</p>
--	------------------------	---	--	------	---

					<p>1. Шивээхүрэн дэх гаалийн газрын ГУБ нараас ирүүлсэн гомдлыг дагуу 01-5/1978 албан тоотоор зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>2. Сахилгын хорооны хурлын шийдвэрийн дагуу Авлигатай тэмцэх газрын хариутай албан тоотод 2025.05.21-ны өдрийн 01-5/2122 албан тоотоор хариуг хүргүүлж, Чингис Хaan Олон Улсын Нисэх буудал дахь гаалийн газарт 01-5/2144 албан тоотоор хугацаатай зөвлөмж, чиглэл хүргүүлсэн.</p> <p>3. СЭГГ-т 2025 оны 04 дүгээр сарын 18-ны 01-5/1583 дугаартай чиглэл хүргүүлэх албан бичгийг хүргүүлсэн.</p> <p><b>Хүрсэн үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Төрийн албаны сахилга, ёс зүйд хяналт тавих үйл ажиллагаа хууль зүйн үндэслэлтэйгээр тогтмол хэрэгжиж байна.</li> <li>Хяналт шалгалтын ажлын хүрээнд зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож, ил тод байдлыг хангаж чадсан.</li> <li>Ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо буурсан нь байгууллагын соёл, хариуцлагын төвшинд эзрэг нөлөө өгч эхэлж буйн илрэл байж болох юм.</li> </ul>	
--	--	--	--	--	--	--

**Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах**

6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Тус нэгж 2024 онд 7 бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрээнд хэрэгжилтийг хангаж ажилласан..	Чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайланг хүргүүлсэн байна.	<p>1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хэсгийн 1.3 дугаар зорилт: “Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бурдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ заалтын хүрээнд тус хэлтсийн нийт ажилтнуудад Монгол бичгийн анхан шатны хичээлийг заалган, сургалт зохион байгуулж байна. Энэхүү ажил нь төрийн албан хаагчдын эх хэлний мэдлэг, хэрэглээг дэмжих, соёлын дархлааг нэмэгдүүлэх бодлогын зорилтыг хангахад чиглэгдсэн.</p> <p>2.Олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил</p> <ul style="list-style-type: none"> <li>2025.01.14-ний өдөр №42 тоот дотоод зурvasaар “Бүгд Найрамдах Беларусь Улсын Гаалийн</li> </ul>	01-01 06-05	100 хувь	

					<p>хороо, Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар" хооронд байгуулж буй эдийн засгийн эрх бүхий операторын (AEO) интитуцийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт Монголын талын саналыг боловсруулан Хуулийн хэлтэст хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Уг санал нь гаалийн хөнгөлөлт, хялбаршуулалтын үйлчилгээг AEO байгууллагуудад нэвтрүүлэх, гадаад худалдааны эргэлтийг дэмжих зорилготой.</li> <li>• ОХУ-ын Гаалийн академийн Владивосток хот дахь салбар, ОХУ-ын Холбооны гаалийн албатай хамтран ажиллах 2025 оны 25-16-09/0042 албан тоотын хүрээнд гаалийн албан хаагчийн авилгыг илүүлэх 16 цагийн багц сургалт лекцид хамрагдах нөхцлийг бүрдүүлсэн.</li> </ul> <p>3. Дотоод хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгосон</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг 2025.04.01-ний өдөр Гаалийн ерөнхий газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2025.04.11-ний А/138 дугаар тушаалаар батлуулсан.</li> <li>• Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг ГЕГ бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хороодод хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.</li> <li>• Шинэчлэгдсэн журам нь гаалийн салбарын дотоод хяналтыг илүү үр дүнтэй, уялдаа холбоотой, хариуцлага хүлээлгэх тогтолцоотой болгоход чиглэгдсэн.</li> </ul>	
7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<p>Хууль, эрх зүйн төсөл, журамд санал боловсруулсан байдал:</p> <p>1. "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай хууль"-ийн төсөлд санал:</p>	01.01-06.05	100 хувь

			<p>Хууль хяналтын байгууллагатай 158 удаагийн албан тоотоор хамтран ажилласан бол нийт 5 эрх зүйн актад санал өгсөн. 40 хувиар үнэлүүлсэн.</p>	<p>Дотоод аюулгүй хэлтсийн хамааралтай шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлagnana.</p>	<p>хяналт, байдлын үйл ажиллагаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлagnana.</p>	<p>2. "Галт зэвсгийн тухай хуулийн" 12.11 дэх заалт болон холбогдох журамд санал боловсруулсан</p> <p>3."Зарим захирагааны хэм хэмжээний актыг хүчингүй болсонд тооцох тухай" төсөлд санал</p> <p>4. "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын төсөл боловсруулсан</p> <p>2025 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан журмын хүрээнд сургалтын саналыг Сургалт судалгааны төвийн төлөвлөгөөнд оруулсан мөн сургалтын гарын авлага бэлдэн ажилласан.</p> <p>5. Хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн санал боловсруулах</p> <p>- "Менежмент ба ур чадварын хүрээлэн" ТББ-тай гэрээ байгуулах ажлын даалгаварт санал өгсөн</p> <p>6. ОБЕГ-аас ирүүлсэн "Гамшгийн аюулын төлөвлөгөө"-нд санал өгсөн</p> <p>7. Авлигатай тэмцэх газарт нотлох баримтын хүргэлт Хийсэн ажил: Эхний хагас жилд 3 удаа нийт 64 хуудас нотлох баримтыг АТГ-т албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>○ 01-5/360 – 43 хуудас</li> <li>○ 01-5/1523 – 6 хуудас</li> <li>○ 01-5/2353 – 15 хуудас</li> <li>○</li> </ul> <p>8.Иргэн, ААН-д тараах авлигын эсрэг "шүгэл үлээх" гарын авлагын загварыг боловсруулсан</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрх зүйн үндэслэл:</li> <li>• Авлигын эсрэг хуулийн 18.1: "Авлигын талаарх мэдээлэл ирүүлэх, шүгэл үлээх хамгаалалтыг хангах."</li> </ul> <p>9. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн бусад ажлууд</p>	
--	--	--	--	---	---	---	--

					<p>-273 дугаар дотоод зурвасаар Ч.Дөлгөөнтэй холбоотой асуудлаар албаны шалгалт хийж, нотлох баримтын шаардлага хангасан материал шүүхэд хүргүүлсэн.</p> <p>- Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх хуралд тус хэлтсийн төлөөлөл оролцож нэхэмжлэлийн шаардлага хангаж ажиллав.</p>		
8	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд нийт гаалийн байгууллагын хэмжээнд судалгаа явуулсны үр дүнд байгууллагын эрсдэл 67% хувиар үнэлэгдсэн.	Нэгжийн ажиллагааны эрсдэлийг таньж тоогоон дүн шинжилгээ хийж, эрсдэл бууруулах арга хэмжээг тухай бүр авсан байна.	<p>Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/342 дугаар тушаалаар баталсан "Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу нэгжийн түвшинд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүng тайлагнаж байна.</p> <p>Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх ажлын хүрээнд хийсэн үйл ажиллагаа</p> <p>1. Эрсдэлийн тодорхойлолт ба судалгааг Хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаатай уялдуулан эрсдэлийг тодорхойлох зорилгоор 14 асуултаас бүрдэх цахим санал асуултыг хэлтсийн нийт албан хаагчдаас авч, нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.</p> <p>Судалгааны зорилго нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>о Үйл ажиллагаанд дотоод эрсдэлийг илрүүлэх</li> <li>о Ажилтнуудын эрсдэлийн талаарх ойлголтыг нэгтгэх</li> <li>о Эрсдэлийг урьдчилан тодорхойлон сэргийлэх арга хэмжээ боловсруулах</li> </ul> <p>2. Эрсдэлийн үнэлгээ</p> <p>Судалгаагаар бүртгэгдсэн 14 эрсдэлд магадлал (Likelihood) болон үр дагавар (Impact)-ын үзүүлэлтээр тооцоо хийж, эрсдэлийн үнэлгээг тоон илэрхийлэлд оруулсан. Үр дүн нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>о Бага эрсдэлтэй – 57.1%</li> <li>о Дунд эрсдэлтэй – 35.7%</li> <li>о Өндөр эрсдэлтэй – 0%</li> </ul> <p>Дүгнэлт:</p> <p>Хэдийгээр өндөр эрсдэл илрээгүй нь сайн үзүүлэлт боловч, дунд болон бага эрсдлийг бууруулах, арилгах зорилгоор тасралтгүй сайжруулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>Эрсдэлийг бууруулах, хяналт сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээ</p>	01-01 06-05	100 хувь

				<p>1.Харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах чиглэл</p> <ul style="list-style-type: none"> <li>о Дотоод харилцааг сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</li> <li>о Багаар ажиллах, харилцааны ур чадвар хөгжүүлэх сургалтыг зохион байгуулахаар Сургалтын төвтэй хамтран ажиллах санал хүргүүлсэн.</li> <li>о Ажилтнуудын хоорондын мэдээллийн солилцоо, уялдаа холбоог сайжруулах зорилгоор дараах хэрэгслийг нэвтрүүлэх:</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li><input type="checkbox"/> Нэгдсэн чат систем</li> <li><input type="checkbox"/> Мэдээллийн самбар</li> <li><input type="checkbox"/> Дотоод мэдээллийн платформ</li> </ul> <p>2. Нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх ажлууд</p> <ul style="list-style-type: none"> <li>о Сайн дурын ажил</li> <li>о Хамт олны арга хэмжээ</li> <li>о Спорт, соёлын арга хэмжээнд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх</li> </ul> <p>Хүрсэн үр дүн</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлийн талаар ажилтнуудын мэдлэг, оролцоо нэмэгдсэн.</li> <li>• Эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн асуудал үүсэх магадлалтай чиглэлүүд тодорхойлогдож, арга хэмжээний төлөвлөлт хийгдсэн.</li> <li>• Хэлтэс дотооддоо хамтран ажиллах уур амьсгал сайжрах нөхцөл бүрдэж байгаа нь ажиглагдсан.</li> <li>• Судалгаанд үндэслэн тогтмол хяналт-шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага илүү тодорхой болсон.</li> <li>Цаашдын төлөвлөгөө</li> <li>• Эрсдэлд суурилсан удирдлагын тогтолцоог тогтвортой хэрэгжүүлэх</li> <li>• Бага болон дунд эрсдлийн түвшинд байгаа асуудлуудыг шийдвэрлэх тодорхой төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>• Журамд нийцсэн эрсдэлийн тайлагналын тогтолцоо бүрдүүлэх</li> </ul> <p>Дүгнэлт</p> <p>"Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ын хүрээнд нэгжийн түвшинд эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд илэрсэн бага, дунд тувшийн эрсдлийг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна. Энэхүү үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулалт хийх нь цаашдын үйл</p>	
--	--	--	--	--	--


					ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлж, байгууллагын тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм.		
9	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.3ДАСП-ын “Үүрэг даалгавар” хэсэгт 2 удаагийн зөвлөмж, 4 үүрэг даалгавар, 1 санал ирснийг хугацаанд биелүүлж, 100 хувиар үнэлүүлсэн. 2.Холбогдох байгууллага, ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажиллаж тухай бүр холбогдох асуудлыг шийдвэрлэн ажиллаж, үүнтэй холбоотой 57 дотоод зурvasыг хүлээн авч хариу ёч, 47 дотоод зурvas хүргүүлсэн.	- Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. - ГЕГ-ын ЗББНДБ болон ХГХ-дод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.	<p>Тайлагнал, мэдээлэл хүргүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> <li>ГЕГ-ын даргад хэлтсийн үйл ажиллагааны талаар 2 цаг үеийн мэдээлэл бэлтгэн хүргүүлэв.</li> <li>ГЕГ-ын дэд даргад 7 хоног бүрийн ажлын гүйцэтгэлийн тайланг тогтмол хугацаанд танилцуулсан.</li> </ul> <p>Төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> <li>2025 оны удирдах ажилтны зөвлөгөөнд хэлэлцүүлэх асуудлын талаар санал, мэдээлэл боловсруулж оролцсон.</li> <li>2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайланг:</li> <li>Сар бүр хэлтсийн ажлыг төлөвлөн гүйцэтгэлийг тайлагнаж байна.</li> </ul> <p>Жил, улирал, сар, 7 хоногоор боловсруулан ГЕГ-ын дэд даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>2025–2028 оны Стратеги төлөвлөгөөний дагуу CERP системд хэлтсийн төлөвлөгөө, тайланг оруулан батлуулсан.</li> </ul> <p>Албан бичиг, гомдол шийдвэрлэлтийн байдал</p> <ul style="list-style-type: none"> <li>160 албан бичиг хүлээн авч, тэдгээрээс: <ul style="list-style-type: none"> <li>147 асуудлыг шийдвэрлэсэн</li> <li>13бичгийг харьяаллын дагуу шилжүүлсэн</li> </ul> </li> <li>Харьяа гаалийн газар, хороо болон хууль хяналтын байгууллагад: <ul style="list-style-type: none"> <li>121 албан бичиг хүргүүлсэн</li> <li>122 бичигт хяналт тавьсан</li> </ul> </li> <li>Иргэдээс ирүүлсэн 6 гомдлыг бичгээр хүлээн авч, шийдвэрлэсэн.</li> </ul>	01-01 06-05	100 хувь

10	Ажлын ашиглалт	цаг	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Алба хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжк, гүйцэтгэх ажлын чанар, ажлын байрны чиг үүрэг, онцлогт тохируулан хэрхэн ажиллах, ажилтнуудын ажлын цаг ашиглалтын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, тухай бүр хяналт тавин ажилласан.	Ажлын цаг ашиглалтыг өмнөх оны мөн үеэс бууруулаагүй байна.	<p>Ажлын цагийн хяналт(CERP)</p> <ul style="list-style-type: none"> <li>Албан хаагчид албаны ажлаар гадуур явах, хувийн шалтгаанаар чөлөө авах зэрэг зайлшгүй шаардлагатай нөхцөл бүрт CERP системд хүсэлт илгээж хэвшишэн.</li> <li>Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нэгжийн бүх албан хаагч цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж хэвшишэн</li> <li>Тайлант хугацаанд ГУБ Ж.Батцэнгэл нь үндэслэлгүйгээр ажил тасалсан зөрчил гаргасан тул сахилгын хорооны хуралд оруулж 1 жилийн хугацаагаар ГУБ (Гаалийн улсын байцаагч)-ийн эрхийг хасах шийтгэл ногдуулсан.</li> </ul> <p>Ээлжийн амралтын зохион байгуулалт</p> <ul style="list-style-type: none"> <li>ГУБ Н.Лхагвадэлгэр, Т.Ууганцэцэг нар ээлжийн амралтаа хуулийн дагуу биөэр эдэлж дуусгасан.</li> </ul>	01-01 06-05	100 хувь
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг Уүргийн хэрэгжилт	чиг	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	- Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухай бүр орж ажилласан байна. Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийн хүрээнд 8 ажил хийгдэж 100 оноогоор дүгнэгдсэн.  - Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухай бүр орж ажилласан байна. -Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. - "Үндсэнай аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд гаалийн байгууллагын 2024 онд хийх ажлын дэд төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<ol style="list-style-type: none"> <li>2025.02.25 № 01-5/871 албан бичгээр Дэлхийн гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын компендиумд тусгасан эрсдэл тооцох аргачлал, Олон улсын валютын сангийн ISO31000 эрсдэлийн удирдлагын зарчим, стандартын дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтэд гарч буй эрсдэлийн судалгааг авч зөвлөмж чиглэл хүргүүлсэн.</li> <li>УАБЗ-ийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг Зөрчилтэй тэмцэх газар чиг үүргийн хүрээнд хариуцана гэж хүлээж авсан тул зөрчлийн газар тайланг өгне.</li> <li>Байгууллагын авлигын эсрэг төлөвлөгөөний дагуу тус хэлтэс хэрэгжүүлэх ажлын тайланг тухай бүр гүйцэтгэн хүргүүлсэн. АТГ-т гэмт хэргийн шинжтэй болон авлига ашиг сонирхолын зөрчилд холбогдсон албан хаагчдыг шилжүүлэн шалгуулж байгаа нь гаалийн байгууллагын авлигын индексийг үндсний хэмжээнд дээшлүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсэн.</li> <li>2025.04.28-ны өдрийн 04/895 дугаартай Төрийн албаны салбар зөвлөлийн хуралд оролцсон.</li> </ol>	01-01 06-05	100 хувь	

					<p>5. ГЕГ-ШУТ-ийн зохион байгуулсан сургалтанд гомдол мэдээллийг хэрхэн бүртгэх, шийдвэрлэлтийн талаар сургалт явуулж 50 албан хаагч оролцсон.</p> <p>6. ХЗДХЯ-д зохион байгуулсан Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал хэлэлцүүлэгт оролцсон.</p> <p>7. ЗГХХГ-аас 2025.03.14-ний 01/325 албан тоотоор ирүүлсэн албан бичгийн дагуу Үндэсний үнэлгээний чадамжийн индекс сургалтанд хамрагдсан.</p> <p>8. ТАЗ-өөс зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.</p> <p>9. Шударга байдлын үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж тайланг хүргүүлсэн.</p> <p>10. Өдөр бүр сошиал болон цахимд тавигдсан гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлтэй танилцан гаалийн байгууллага албан тушаалтантай холбоотой мэдээ мэдээллийг шалгаж бодит байдлыг тогтоон удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>11. Шударга бус байдлыг тэвчихгүй сэдэвтэй брошур болон Иргэдэд зориулсан анхааруулга, санамж, зөвлөмж Шүгэл үлээгчийн талаарх ойлголт, эрх зүйн үндэслэлийн талаарх анхааруулга зөвлөмжийг олон нийтэд сурталчилах ажлын тус тус зохион байгуулав.</p>	
--	--	--	--	--	---	--

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
( Албан тушаал )



..... / Л.Очгэрэл/  
( Нэр, гарын үсэг )

2025 оны 06 сарын 10

( Огноо )

ДОТООД ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОЧГЭРЭЛИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгкүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин		Хүрсэн түвшин (биелэлт)		
1	2	3	4		5		6	7
1	Дотоод хяналт, аюулгүй байдлын чиглэлээр богино болон урт хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	1. ОХУ-ын Гаалийн академийн Владивосток хот дахь салбар, ОХУ-ын Холбооны гаалийн албатай хамтран ажиллах 2025 оны 25-16-09/0042 албан тоотын хүрээнд гаалийн албан хаагчийн авилгыг илүүлэх, түүнтэй тэмцэх 16 цагийн багц сургалт лекцид хамрагдахаар Гаалийн ерөнхий газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэсээр дамжуулан /2025.04.01-ний 316 дотоод зурvas/ хэлтсийн албан хаагчдыг хамруулах саналаа ОХУ-ын гаалийн албанад хүргүүлэн шийдвэрлэсэн. 2. Монгол бичгийн сургалтыг зохион байгуулан суралцаж байна.	01.01-06.10	100	
2	Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдах	Сертификатын тоо	-	Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандaa нэвтрүүлсэн байна.	Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдсан хэдий ч шалгалт хойшилсон тул сертификат аваагүй.	01.01-06.10	100	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ДОТООД ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
/Л.ОЧГЭРЭЛ/ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ДОТООД ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОЧГЭРЭЛИЙН 2025 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ  
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар  
Нэгжийн нэр: Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		61,5

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдах		14,5
<b>Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:</b>			14,5

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	13
2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	12
4.	Манлайлах	12
5.	Багаар ажиллах	12
6.	Харилцаа	12
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.  Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо	12

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	61,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14,5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	18
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	-
<b>Нийт оноо=</b>		88
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		

**Үнэлгээ өгсөн:**

Гаалийн ерөнхий газрын дарга

**Төсвийн шууд захирагч:**

(Р.Отгонжаргал)

2025.06.26 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн дарга

**Нэгжийн дарга:**

(Л.Очгэрэл)

2025.06.10 (огноо)